

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны ... дүгээр сарын .....-ний өдөр

Улаанбаатар хот

### ЦУСНЫ ДОНОРЫН ТУХАЙ

#### НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

##### **1 дүгээр зүйл.Хуулийн зорилт**

1.1.Энэ хуулийн зорилт нь цусны донорын үйл ажиллагаатай холбоотой төрийн бодлого, зохицуулалт, баримтлах зарчим, түүнийг хэрэгжүүлэх байгууллагын эрх зүйн үндэс, санхүүжилтийн тогтолцоо, төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалтан, иргэний эрх, үүрэг, цус сэлбэлт судлалын албанд ажиллагсадын цалин, хөлс, нийгмийн баталгаатай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

##### **2 дугаар зүйл.Цусны донорын хууль тогтоомж**

2.1.Цусны донорын тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, олон улсын гэрээ, Эрүүл мэндийн тухай хууль, Монголын улаан загалмай нийгэмлэгийн эрх зүйн байдлын тухай хууль, энэ хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

##### **3 дугаар зүйл.Хуулийн нэр томьёо**

3.1.Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томьёог доор дурдсан утгаар ойлгоно:

3.1.1.“цусны донорын үйл ажиллагаа” гэж цусны донорын сургалт, сурталчилгаа, цусны донорыг сонгох, элсүүлэх, эрүүл мэндийн үзлэг хийх, цус цуглуулах, шинжлэх, боловсруулах, хадгалах, тээвэрлэх, сэлбэх болон цусны аюулгүй байдлыг хангахтай холбоотой үйл ажиллагааны цогцыг;

3.1.2.“цусны донорын үйл ажиллагааны тогтолцоо” гэж цусны донорын үйл ажиллагаанд тавих төрийн хяналт, оролцоо, байгууллагуудын эрх, үүрэг, санхүүжилтийн тогтолцоог;

3.1.3.“бүхэл цус” гэж донороос эмчилгээний зорилгоор цусны эс, сийвэнг ялгахгүйгээр авч байгаа цусыг;

3.1.4.“ховор бүлгийн цус” гэж хүн амын цусны бүлэгт эзлэх хувь багатай, резус сөрөг бүлгийн цусыг;

3.1.5.“цус, цусны бүрэлдэхүүн хэсэг” гэж бүхэл цус, цусны эс, сийвэнг;

3.1.6.“цус, цусан бүтээгдэхүүн” гэж донорын цусыг боловсруулж бэлтгэсэн бүтээгдэхүүнийг;

3.1.7.“сэлбүүлэгч” гэж амь нас, эрүүл мэндээ хамгаалуулах зорилгоор цус, цусан бүтээгдэхүүн сэлбүүлэх зайлшгүй шаардлагатай хүнийг;

3.1.8.“цус, түүний бүрэлдэхүүн хэсгийг боловсруулах” гэж цус, түүний бүрэлдэхүүн хэсгийг технологийн горимын дагуу үйлдвэрлэлийн аргаар бэлтгэхийг;

3.1.9.“эрүүл мэндийн үзлэг” гэж эрүүл мэнд, тавигдах шаардлагын хувьд цусны донор болох боломжтой эсэхийг тодруулах зорилгоор хийгдэж байгаа эмчийн үзлэгийг;

3.1.10.“цусны аюулгүй байдал” гэж цусны донор элсүүлэх, цус, цусны бүрэлдэхүүн хэсгийг авах, шинжлэх, боловсруулах, хадгалах, тээвэрлэх, сэлбэх, экспортлох, импортлох ажиллагаанд хууль, журам, стандартын шаардлага бүрэн хангагдсан байдлыг;

3.1.11.“хөдөлгөөнт иж бүрдэл” гэж автотээврийн хэрэгсэлд суурилан сургалт, сурталчилгаа хийх, цус, түүний бүрэлдэхүүн хэсгийг цуглуулах зориулалтаар тоногдсон иж бүрдлийг;

#### **4 дүгээр зүйл.Цусны донорын үйл ажиллагаанд баримтлах зарчим**

4.1.Цусны донорын үйл ажиллагаанд дараах зарчмыг баримтална:

4.1.1.хууль, хүний эрхийг дээдлэх;

4.1.2.сайн дурын, авлагагүй байх;

4.1.3.аюулгүй, чанарын баталгаатай байх;

4.1.4.цусны донор, сэлбүүлэгчийн эрүүл мэндийг хамгаалах;

4.1.5.хүний эмзэг мэдээллийг хамгаалах;

4.1.6.шинжлэх ухаан, технологийн тэргүүлэх чиглэл байх;

4.1.7.цусны донорыг алдаршуулж, урамшуулах.

### **ХОЁРДУГААР БҮЛЭГ ЦУСНЫ ДОНОРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТОГТОЛЦОО**

**5 дугаар зүйл.Цусны донорын үйл ажиллагаан дахь төрийн зохицуулалт, хяналт**

5.1.Цусны донорын үйл ажиллагааны төрийн зохицуулалт нь сайн дурын, авлагагүй цусны донорын хөдөлгөөнийг идэвхижүүлэх, цус, цусан бүтээгдэхүүний нөөц, хангамж, аюулгүй байдлыг хангах, цусны донорын үйл ажиллагааг зохицуулахад чиглэнэ.

5.2.Цусны донорын үйл ажиллагаанд тавих төрийн хяналтад дараах зүйлийг ойлгоно:

5.2.1.эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас цус, сэлбэлт судлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулах эрх олгох зөвшөөрлийн хяналт;

5.2.2.эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас цус, түүний бүрэлдэхүүн хэсгийн цуглуулалт, шинжилгээ, боловсруулалт, хадгалалт, тээвэрлэлт, цус сэлбэх үйл ажиллагаа, түүнээс үүдсэн урвал, хүндрэл, шинжилгээний баталгаажилттай холбоотой тавих хяналт;

5.2.3.цусны донорын мэдээллийн санд тавих хяналт.

## **6 дугаар зүйл.Цусны донорын үйл ажиллагааны талаархи Засгийн газрын бүрэн эрх**

6.1.Цусны донорын үйл ажиллагааны талаар Засгийн газар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

6.1.1.цус, цусан бүтээгдэхүүний нөөц, хангамж, чанар, аюулгүй байдлын талаар баримтлах төрийн бодлогыг Улсын Их Хурлаар батлуулах, биелэлтийг хангах;

6.1.2.Засгийн газар хоорондын болон олон улсын байгууллагатай гэрээ, хэлэлцээр байгуулах, төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх;

6.1.3.цус, цусан бүтээгдэхүүний нөөц, хангамж, чанар, аюулгүй байдлыг хангах тогтолцоог бүрдүүлэх, санхүүжилтийг шийдвэрлэх;

6.1.4.гамшгийн үед цус, цусан бүтээгдэхүүн, тэдгээрийг орлох бэлдмэлийн нөөцийг бүрдүүлж, бэлэн байдлыг хангах;

6.1.5.Засгийн газрын шагнал Цусны Хүндэт донор энгэрийн тэмдэгээр шагнах, тэдэнд дэмжлэг үзүүлэх журам батлах;

6.1.6.цус сэлбэлт судлалын салбарт ажиллагсдын нэмэгдэл цалингийн хэмжээг тогтоох, нийгмийн баталгааг хангах арга хэмжээ хэрэгжүүлэх;

6.1.7.хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.

## **7 дугаар зүйл.Цусны донорын үйл ажиллагаанд оролцогч байгууллага**

7.1. Монгол Улсын нутаг дэвсгэрт цусны донороос цус, түүний бүрэлдэхүүн хэсгийг цуглуулах, шинжлэх, боловсруулах, хадгалах, тээвэрлэх, сэлбэхтэй холбоотой асуудлаар чиг үүрэг, үйл ажиллагааны чиглэлээр хамтран ажилладаг дараах байгууллагууд багтана:

7.1.1.эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага;

7.1.2.цус сэлбэлт судлалын асуудал эрхэлсэн тусгай мэргэжлийн төв;

7.1.3.цусны донорын үйл ажиллагаанд оролцогч эрүүл мэндийн байгууллага, анагаах ухааны боловсрол олгодог боловсролын байгууллага;

7.1.4.төрийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах байгууллага;

7.1.5.Монголын улаан загалмайн нийгэмлэг, бусад төрийн бус байгууллага;

7.1.6.аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтан.

7.2.Цусны донорын үйл ажиллагааг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага зохицуулна.

7.3.Цус донорын үйл ажиллагааг мэргэжил, арга зүйн удирдлагаар цус сэлбэлт судлалын асуудал эрхэлсэн тусгай мэргэжлийн төв хангана.

## **8 дугаар зүйл.Цусны донорын үйл ажиллагаан дахь удирдлагын тогтолцоо**

8.1.Цусны донорын үйл ажиллагааны удирдлагын тогтолцоо нь эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, цус сэлбэлт судлалын асуудал хариуцсан тусгай мэргэжлийн төв, бусад эрүүл мэндийн байгууллага, Монголын улаан загалмай нийгэмлэг, нутгийн өөрөө удирдах байгууллагын удирдлага болон Засаг даргаас бүрдэнэ.

## **9 дүгээр зүйл.Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын эрх, үүрэг**

9.1.Цусны донорын үйл ажиллагааны талаар эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараах эрх, үүрэгтэй:

9.1.1.цусны донорын үйл ажиллагааг зохицуулах хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах;

9.1.2.цус, цусан бүтээгдэхүүний нөөц, хангамж, чанар, аюулгүй байдал, цус сэлбэх тогтолцоог бүрдүүлэхтэй холбоотой төрөөс баримтлах бодлого боловсруулах;

9.1.3.цусны донорын үйл ажиллагаанд төрийн хяналт хэрэгжүүлэх;

9.1.4.цус сэлбэлт судлалын асуудал эрхэлсэн тусгай мэргэжлийн төвийн дүрэм, бүтцийг батлах;

9.1.5.цусны аюулгүй байдлыг хангах, цусны донорын үйл ажиллагааг зохицуулах журмыг батлах, хэрэгжилтэд хяналт тавих;

9.1.6.цусны донорын үйл ажиллагаанд ашиглах техник, технологийн чиглэлээр баримтлах бодлого батлах;

9.1.7.цус, түүний бүрэлдэхүүн хэсгээ өгсөн донорт олгох илчлэг нөхөх хүнсний бүтээгдэхүүний орц, илчлэгийн жишиг хэмжээг батлах;

9.1.8.цус сэлбэлт судлалын салбарт ажиллагсдын нэмэгдэл цалингийн хэмжээг тогтоох, нийгмийн баталгааг хангах санал боловсруулах;

9.1.9.улсын хэмжээнд онцлог үйл ажиллагаа явуулдаг байгууллагын хувьд цус сэлбэлт судлалын чиглэлээр ажилладаг эмнэлгийн мэргэжилтнийг гадаад орны ижил төстэй үйл ажиллагаа бүхий байгууллагын төгсөлтийн дараах сургалт, дадлагад хамруулан мэргэшүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэх;

9.1.10.хуульд заасан бусад эрх, үүрэг.

**10 дугаар зүйл. Цус сэлбэлт судлалын асуудал хариуцсан эрүүл мэндийн байгууллагын эрх, үүрэг**

10.1.Цус сэлбэлт судлалын асуудал хариуцсан эрүүл мэндийн байгууллага нь Эрүүл мэндийн тухай хуулийн 15.1.12-д заасан тусгай мэргэжлийн төв байх бөгөөд мөн хуулийн 16.15-д заасан эрх, үүргээс гадна дараах эрх, үүрэгтэй:

10.1.1.цусны донорын сургалт, сурталчилгааны ажлыг мэргэжил, арга зүйгээр хангах, төрийн болон төрийн бус байгууллага, иргэдтэй хамтран зохион байгуулах;

10.1.2.цусны донорт эрүүл мэндийн үзлэг хийх, сонгох;

10.1.3.цуглуулсан цус, түүний бүрэлдэхүүн хэсэгт цус сэлбэлтээр дамжих халдвар илрүүлэх, цусны бүлэг тодорхойлох, бүтээгдэхүүний чанарын баталгаа хангах болон бусад шинжилгээ хийх;

10.1.4.цус, түүний бүрэлдэхүүн хэсгийг боловсруулж, цус, цусан бүтээгдэхүүн үйлдвэрлэх;

10.1.5.цус, цусан бүтээгдэхүүний нөөц, хангамжийн тогтвортой байдлыг хангах;

10.1.6.донорт цусаа бэлэглэсэн талаарх магадлагаа олгох;

10.1.7.цусны донорыг алдаршуулах, урамшуулах үйл ажиллагааг төрийн болон төрийн бус байгууллага, иргэдтэй хамтран зохион байгуулах;

10.1.8.олон удаа цус, түүний бүрэлдэхүүн хэсгээ бэлэглэсэн цусны донорыг шагнах, Засгийн газрын болон төрийн шагналд нэр дэвшүүлэх;

10.1.9.цусны чанар, аюулгүй байдал, цус, цусан бүтээгдэхүүний зохистой хэрэглээ, цусны сонор сэрэмжийн тогтолцоог үндэсний хэмжээнд удирдлага зохион байгуулалт, мэргэжил арга зүйгээр хангах;

10.1.10.цусны донорын үйл ажиллагаанд ашиглах техник, технологийн сонголт, шинэчлэл хийх;

10.1.11.цусны донорын мэдээллийн сангийн бүрдүүлэлт, өөрчлөлт, хадгалалт, хамгаалалт, аюулгүй байдлыг хариуцах талаар хууль, тогтоомжоор тогтоосон үүргийг хэрэгжүүлэх;

10.1.12.цус, цусан бүтээгдэхүүний үйлдвэрлэл, хэрэглээ, нөөц, хангамжийг зохицуулах, хадгалах, хянах, мэдээ, тайланг улсын хэмжээнд нэгтгэн гаргах, холбогдох байгууллагад хүргүүлэх.

10.2.Цус, сэлбэлт судлалын тусгай мэргэжлийн төвийн харьяанд Цусны төв байгуулж болно.

**11 дүгээр зүйл. Цусны төвийн эрх, үүрэг**

## 11.1.Цусны төв дараах эрх, үүрэгтэй:

11.1.1.цусны донорын сургалт, сурталчилгааг төрийн болон төрийн бус байгууллага, иргэдтэй хамтран зохион байгуулах;

11.1.2.цусны донорт эрүүл мэндийн үзлэг хийх, сонгох;

11.1.3.цусны донороос цус, түүний бүрэлдэхүүн хэсэг авах, түүнд цус сэлбэлтээр дамжих халдвар илрүүлэх, бүлэг тодорхойлох болон бусад шинжилгээ хийх;

11.1.4.цус, түүний бүрэлдэхүүн хэсгийг боловсруулж, цус, цусан бүтээгдэхүүн үйлдвэрлэх;

11.1.5.орон нутгийн хэмжээнд цус, цусан бүтээгдэхүүний нөөц, хангамжийн тогтвортой байдлыг хангах;

11.1.6.орон нутгийн эрүүл мэндийн байгууллагуудад цус сэлбэлт судлалын чиглэлээр мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх;

11.1.7.донорт цусаа бэлэглэсэн талаарх магадлагаа олгох;

11.1.8.цусны донорыг алдаршуулах, урамшуулах үйл ажиллагааг төрийн болон төрийн бус байгууллага, иргэдтэй хамтран зохион байгуулах;

11.1.9.олон удаа цус, түүний бүрэлдэхүүн хэсгээ өгсөн цусны доноруудыг цус сэлбэлт судлалын асуудал хариуцсан тусгай мэргэжлийн төвд уламжлан Засгийн газрын болон төрийн шагнал, бусад шагналд нэр дэвшүүлэх;

11.1.10.цус, цусан бүтээгдэхүүний хэрэглээ, нөөц, хангамжийг орон нутгийн хэмжээнд зохицуулах, хадгалах, хянах, мэдээ, тайланг нэгтгэн, цус, сэлбэлт судлалын асуудал хариуцсан тусгай мэргэжлийн төвд хүргүүлэх.

11.2.Цусны төв нь цус сэлбэлт судлалын тусгай мэргэжлийн төвийн харьяанд, эсхүл аймаг, сумын Нэгдсэн эмнэлгийн дэргэд бие даасан хэлбэртэй байж болно.

11.3.Цусны төвийн бүтэц, орон тооны дээд хязгаарыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тогтооно.

11.4.Цусны төвийн цуглуулсан цусны нэгж бүрт цус сэлбэлтээр дамжих халдвар илрүүлэх шинжилгээг холбогдох эрүүл мэндийн байгууллага хийнэ.

## **12 дугаар зүйл.Цусны донорын үйл ажиллагаанд оролцогч бусад эрүүл мэндийн байгууллагын эрх, үүрэг**

12.1.Бусад эрүүл мэндийн байгууллага нь дараах эрх, үүрэгтэй:

12.1.1.цусны аюулгүй байдлыг хангах, цус, цусан бүтээгдэхүүнийг зөв тээвэрлэх, хадгалах, цус сэлбэлтийн өмнөх шинжилгээ хийх, сэлбэлтийн үеийн аюулгүй байдлыг хангах, цус, цусан бүтээгдэхүүн сэлбэхтэй холбоотойгоор сэлбүүлэгчид учирч болзошгүй урвал, хүндрэлээс сэргийлэх;

12.1.2.цус, цусан бүтээгдэхүүний зохистой хэрэглээг хэрэгжүүлэх;

12.1.3.цус, түүний бүрэлдэхүүн хэсгийг авах үед цусны донорт, цус, цусан бүтээгдэхүүн сэлбэх үед сэлбүүлэгчид учирсан урвал, хүндрэлийн үед яаралтай болон нарийн мэргэжлийн тусламж үзүүлэх;

12.1.4.цус, цусан бүтээгдэхүүний хэрэглээ, нөөц, хангамжийг эмнэлгийн хэмжээнд зохицуулах, хадгалах, хянах, мэдээ, тайланг нэгтгэн, цус, сэлбэлт судлалын асуудал хариуцсан тусгай мэргэжлийн төвд хүргүүлэх.

### **13 дугаар зүйл.Нутгийн өөрөө удирдах байгууллага, Засаг даргын эрх, үүрэг**

13.1.Нутгийн өөрөө удирдах байгууллага, Засаг дарга дараах эрх, үүрэгтэй:

13.1.1.цусны донорын үйлсийг сурталчлах, эгнээг өргөжүүлэх, донор хадгалалтыг сайжруулах үйл ажиллагааг дэмжих, цусны донорыг алдаршуулах, урамшуулах;

13.1.2.гамшиг, нийгмийн эрүүл мэндийн онцгой байдлын үед харьяа нутаг дэвсгэрийн хэмжээнд эрүүл мэндийн байгууллагад цус, цусан бүтээгдэхүүний нөөц бүрдүүлэх, нөхөн сэлбэхэд шаардагдах нэмэлт санхүүжилтийг шийдвэрлэж, удирдлага зохион байгуулалтаар хангах.

### **14 дүгээр зүйл.Бусад байгууллагын оролцоо**

14.1.Төрийн цэргийн болон цагдаагийн байгууллагын албан тушаалтан ажил олгогч нь дараах үүрэгтэй:

14.1.1.цусны донорын үйлсийг сурталчлах, эгнээг өргөжүүлэх, донор хадгалалт, цус, цусан бүтээгдэхүүний нөөц, хангамжийн тогтвортой байдлыг хангах үйл ажиллагааг дэмжих;

14.1.2.цусны донорын үйл ажиллагаанд оролцогч байгууллагуудад цус, түүний бүрэлдэхүүн хэсэг цуглуулах үйл ажиллагаа зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх;

14.1.3.бие бүрэлдэхүүнээ цусны донорын үүргээ биелүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх;

14.1.4.цус, түүний бүрэлдэхүүн хэсгээ өгсөн ажилтан, цэргийн алба хаагчид хууль тогтоомжоор тогтоосон олговор олгох;

14.1.5. цус, түүний бүрэлдэхүүн хэсэг цуглуулахад шаардлагатай байраар үнэ төлбөргүй хангах;

14.1.6.цэрэг, цагдаагийн албан хаагч цусны донорыг цусаа өгсөн өдөр нь энэ хуулийн 10.1.6, 11.1.7-д заасан магадлагааг үндэслэн харуул, манаа болон цэргийн албаны бусад үүрэг гүйцэтгэхээс чөлөөлөх;

14.1.7.цэрэг, цагдаагийн албан хаагч цусны донорт цусаа бэлэглэсэн өдөрт нь энэ хуулийн 10.1.6, 11.1.7-д заасан магадлагааг үндэслэн чөлөө, Хөдөлмөрийн тухай хуулийн 117.2-т заасан олговор олгох, алдаршуулах, урамшуулах;

14.2.Аж ахуйн нэгж байгууллагын албан тушаалтан, ажил олгогч нь дараах үүрэгтэй:

14.2.1.цусны донорын үйлсийг сурталчлах, эгнээг өргөжүүлэх, донор хадгалалтыг сайжруулах үйл ажиллагааг дэмжих;

14.2.2.хэвлэл мэдээллийн хэрэгсэл нь авлагагүй, сайн дурын цусны донорын талаар нийгэмд чиглэсэн ашгийн бус сурталчилгаа явуулах;

14.2.3.цусны донорын үүргээ гүйцэтгэсэн ажилтанд энэ хуулийн 10.1.6, 11.1.7-д заасан магадлагааг үндэслэн чөлөө, Хөдөлмөрийн тухай хуулийн 117.2-т заасан олговор олгох, алдаршуулах, урамшуулах.

14.3.Анагаах ухааны боловсрол олгох боловсролын байгууллага нь сургалтын хөтөлбөртөө цус сэлбэлт судлалын сургалтын агуулгыг тусгана.

### **15 дугаар зүйл.Санхүүжилтийн тогтолцоо**

15.1.Цусны донорын үйл ажиллагааны санхүүжилт нь улсын болон орон нутгийн төсөв, цус сэлбэлт судлалын асуудал хариуцсан эрүүл мэндийн байгууллагын өөрийн орлого, аж ахуйн нэгж, байгууллага, хамт олон, иргэний хандив, хууль тогтоомжоор хориглоогүй бусад эх үүсвэрээс бүрдэнэ.

15.2.Цус сэлбэлт судлалын асуудал хариуцсан эрүүл мэндийн байгууллагын өөрийн орлогоор Төсвийн тухай хуулийн 18.7-д заасны дагуу эргэлтийн сан байгуулах бөгөөд уг сангийн хөрөнгийг дараах зорилгоор ашиглаж болно:

15.2.1.цусны донорын үйлсийг сурталчлах, донорт элсүүлэх;

15.2.2.цусны донорыг алдаршуулах, урамшуулах;

15.2.3.цусны донорт илчлэг нөхөх хүнсний бүтээгдэхүүн олгох;

15.2.4.цус, сэлбэлт судлалын чиглэлээр эмнэлгийн мэргэжилтнийг гадаад оронд төгсөлтийн дараах сургалт, дадлагад хамруулах;

15.2.5.эрдэм шинжилгээ, судалгааны төсөл хэрэгжүүлэх, техникийн болон мэдээллийн технологийн засвар, шинэчлэл хийх;

15.2.6.цус сэлбэлт судлалын асуудал хариуцсан тусгай мэргэжлийн төв, цусны төвийн ажилтны нэмэгдэл цалин, урамшуулал, нийгмийн асуудлыг шийдвэрлэх.

15.3.Цусны донорын үйлсийг сурталчлах, элсүүлэхэд санхүү, эд материалын дэмжлэг үзүүлсэн аж ахуйн нэгж байгууллагын тухайн үйл ажиллагаанд зарцуулсан хөрөнгийг цус сэлбэлт судлалын асуудал хариуцсан эрүүл мэндийн байгууллагын тодорхойлолтыг үндэслэн аж ахуйн нэгжийн орлогын албан татвараас чөлөөлнө.

15.4.Цус, цусан бүтээгдэхүүний үнийг санхүү, төсвийн болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.

15.5.Цус, сэлбэлт судлалын асуудал хариуцсан тусгай мэргэжлийн төв, Цусны төвийн ажилтнуудад Төрийн албаны тухай хууль, Эрүүл мэндийн тухай хуульд заасан нэмэгдлээс гадна сар бүр цусны албаны нэмэгдэл цалин олгоно.



15.6.Цусны албаны нэмэгдэл цалингийн хэмжээг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний саналыг үндэслэн Засгийн газар тогтооно.

## **ГУРАВДУГААР БҮЛЭГ ЦУСНЫ ДОНОР, СЭЛБҮҮЛЭГЧ, ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГА, АЖИЛТАНД ТАВИГДАХ ШААРДЛАГА**

### **16 дугаар зүйл.Цусны донорт тавигдах шаардлага**

16.1.Хүний эрүүл мэндийг хамгаалах, амь насыг аврахад зориулан цус, түүний бүрэлдэхүүн хэсгээ сайн дурын үндсэн дээр, авлагагүйгээр өгөх хүсэлтэй, эрүүл мэндийн хувьд харшлах шалтгаангүй, иргэний эрх зүйн бүрэн чадамжтай Монгол Улсын иргэн, Монгол Улсад зургаан сараас багагүй хугацаанд байнга оршин сууж байгаа гадаад улсын иргэн, харьяалалгүй хүн цусны донор болж болно.

16.2.Цусны донорыг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхахыг хориглоно.

16.3.Цусны донорт дараах ерөнхий шаардлага тавигдана:

16.3.1.цусны донорт тавигдах эрүүл мэндийн шалгуур үзүүлэлтийг хангасан байх;

16.3.2.эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын баталсан цусны донор сонгох асуумжтай танилцаж, зөвшөөрлөө өгсөн байх;

16.3.3.өөрийн эрүүл мэндийн байдлыг үнэн зөвөөр мэдэгдсэн байх.

### **17 дугаар зүйл.Цус, цусан бүтээгдэхүүн сэлбүүлэгчид тавигдах шаардлага**

17.1.Иргэн эрүүл мэндээ сайжруулах, амь насаа аврах зорилгоор донорын цус, цусан бүтээгдэхүүн сэлбүүлж болно.

17.2. Цус, цусан бүтээгдэхүүн сэлбүүлэгчид дараах ерөнхий шаардлага тавигдана:

17.2.1.эмчилгээний зорилгоор цус, цусан бүтээгдэхүүн сэлбэх эмчийн шийдвэртэй байх;

17.2.2.Цус, цусан бүтээгдэхүүн сэлбэх зөвшөөрлийг цус сэлбэлтийн улмаас эрүүл мэндэд нь үүсч болзошгүй үр дагаварын талаар танилцан, иргэний эрх зүйн бүрэн чадамжтай сэлбүүлэгч өөрөө, хүүхэд болон эрх зүйн бүрэн чадамжгүй иргэний эцэг, эх, хууль ёсны асран хамгаалагч, харгалзан дэмжигч бичгээр зөвшөөрсөн байх;

17.3.Сэлбүүлэгч өөрөө зөвшөөрөл өгөх, эцэг, эх, хууль ёсны асран хамгаалагч, харгалзан дэмжигчид мэдээлэх боломжгүй болон цус, цусан бүтээгдэхүүн сэлбэхийг зөвшөөрөөгүй тохиолдолд холбогдох хууль, эмчилгээний зааврыг баримтлан Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 1-д заасны дагуу эмнэлгийн мэргэжилтэн, цус сэлбэлтийг зохицуулах зөвлөл шийдвэр гаргана.

17.4.Сэлбүүлэгч нь цус сэлбэлттэй холбоотой дүрэм, журам, мэргэжлийн багийн зөвлөгөөг чанд мөрдөх үүрэгтэй.

## **18 дугаар зүйл.Цусны донорын эрх, үүрэг**

18.1.Цусны донорын үүрэг гүйцэтгэж байгаа иргэн дараах эрх эдэлнэ:

18.1.1.энэ хуулийн дагуу цус, түүний бүрэлдэхүүн хэсгээ авлагагүйгээр өгөх;

18.1.2.цус, түүний бүрэлдэхүүн хэсгээ өгөх явцдаа өөрийн эрүүл мэнд, амь насыг төрөөр хамгаалуулах;

18.1.3.цусны донорын үүргээ гүйцэтгэх үедээ Хөдөлмөрийн тухай хуулийн 117.2-т заасан дундаж цалин хөлстэй тэнцэх олговор авах;

18.1.4.өөрийн цус, түүний бүрэлдэхүүн хэсэгт хийсэн шинжилгээний хариутай танилцах;

18.1.5.цус, түүний бүрэлдэхүүн хэсгээ өгснөөр өөрийн эрүүл мэндэд учирч болох үр дагаварын талаар бүрэн мэдээлэл авах;

18.1.6.цусны донорын үүрэг гүйцэтгэж байхад сөрөг хариу урвал үүссэн тохиолдолд тогтоосон стандартын дагуу үнэгүй эмнэлгийн тусламж авах;

18.1.7.цус, түүний бүрэлдэхүүн хэсгээ өгөх үүргээ биелүүлсэнтэй холбоотой амь нас, эрүүл мэндэд нь учирсан хохирлоо нөхөн төлүүлэх;

18.1.8.цусны донорын үйлсийг сурталчлах, эгнээг өргөжүүлэх ажилд сайн дураар оролцох;

18.1.9. ажиллаж байгаа байгууллагын удирдлагатай тохиролцсоны дагуу хүссэн үедээ цусаа бэлэглэх, цус өгсөн өдрөө цалинтай чөлөө авах, чөлөөлөөгүй тохиолдолд тухайн өдрийн цалингаа нэг аравны тав дахин өсгөж авах;

18.1.10.цэргийн албан хаагч цусны донорын хувьд цус өгсөн өдөр харуул, манаа, цэргийн албаны бусад үүрэг гүйцэтгэхээс чөлөөлөгдөх;

18.1.11.энэ хууль, бусад хууль тогтоомжоор тогтоосон дэмжлэг хүртэх.

18.2.Цусны донорын үүрэг гүйцэтгэж байгаа иргэн дараах үүрэгтэй:

18.2.1.иргэний үнэмлэх болон хувийн байдал тогтоох боломжтой бичиг баримтаа үзүүлэх;

18.2.2.цус өгөхийн өмнө өвчилсөн өвчин, эмгэгийн байдал, халдварт өвчний голомтот нутагт зорчсон эсэх, мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх бодис хэрэглэсэн эсэх, хүнд, хортой орчинд ажилладаг эсэх болон дархлаажуулалтад хамрагдсан талаар үнэн, зөв мэдээлэх;

18.2.3.цус өгөхийн өмнө хийгдэх шинжилгээнд бүрэн хамрагдах;

18.2.4.эрүүл мэндийн үзлэгт хамрагдах;

18.2.5.цусны донорын талаар эрх бүхий байгууллагаас гаргасан хууль, эрх зүйн актыг мөрдөх.

18.3.Цусны донорын үүрэг гүйцэтгэх үедээ мэдэж байсан эрүүл мэндтэй холбоотой мэдээллээ нуусан, худал мэдээлснээс сэлбүүлэгчийн эрүүл мэнд, амь насанд аюул учруулсан, аюул учрах нөхцөл бий болгосон бол хуульд заасан хариуцлага хүлээнэ.

### **19 дүгээр зүйл. Цусны донорт хийх эрүүл мэндийн үзлэг**

19.1.Цусны донорт цус, түүний бүрэлдэхүүн хэсгээ өгөхөөс өмнө эрүүл мэндийн үзлэг хийнэ.

19.2.Эрүүл мэндийн үзлэг хийсэн эмнэлгийн мэргэжилтэн донорыг цус, түүний бүрэлдэхүүн хэсгээ өгөх боломжтой эсэх, цусны донорын шалгуурт тэнцэх эсэх дүгнэлтийг бие даан гаргана.

### **20 дугаар зүйл.Цусны донорын үйл ажиллагаанд оролцогч эмнэлгийн мэргэжилтэнд тавигдах шаардлага**

20.1.Цусны донорт үзлэг хийх, цус, түүний бүрэлдэхүүн хэсэг авах, боловсруулах, хадгалах үйл ажиллагааг мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл, цус, сэлбэлт судлалын чиглэлээр төрөлжсөн мэргэшил эзэмшсэн эмнэлгийн мэргэжилтэн гүйцэтгэнэ.

20.2.Цуглуулсан цусанд шинжилгээ хийх үйл ажиллагааг мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл, төрөлжсөн мэргэшил эзэмшсэн эмч, анагаах ухааны боловсрол олгодог боловсролын сургууль төгссөн эмнэлэгийн мэргэжилтэн гүйцэтгэнэ.

20.3.Эмч, эмнэлгийн мэргэжилтэн цусны донор болон сэлбүүлэгчийн нууцыг хадгалж, эрүүл мэндийн үзлэг болон шинжилгээний хариуг зөвхөн өөрт нь мэдээлнэ.

20.4.Цусны донорын мэдээллийг сэлбүүлэгчид, сэлбүүлэгчийн мэдээллийг цусны донорт мэдээлэхгүй.

### **21 дүгээр зүйл.Цус, түүний бүрэлдэхүүн хэсэг авахтай холбоотой эмнэлгийн мэргэжилтний эрх, үүрэг**

21.1.Эмнэлгийн мэргэжилтэн дараах эрх эдэлнэ:

21.1.1.цус, түүний бүрэлдэхүүн хэсэг цуглуулахтай холбоотой асуудлаар иргэн, байгууллага, албан тушаалтанд мэргэжлийн зөвлөгөө өгөх, шаардлага тавих;

21.1.2.цус, түүний бүрэлдэхүүн хэсгээ өгөхийг хүсэгчийн иргэний үнэмлэх болон хувийн байдал тогтоох боломжтой бичиг баримтыг шалгах;

21.1.3.цусны донор, сэлбүүлэгчийн эрүүл мэндэд хохирол учрахаар бол цус, түүний бүрэлдэхүүн хэсгээ өгөхийг түр болон бүр хориглох шийдвэр гаргах;

21.1.4.цусны донорын үүргээ гүйцэтгэсэн тухай магадлагаа олгох;

21.1.5.хууль, тогтоомжоор хүлээсэн үүргээ биелүүлэхийг шаардах;

21.1.6.хууль тогтоомжид заасан бусад эрх.

21.2. Эмнэлгийн мэргэжилтэн дараах үүрэгтэй:

21.2.1.цусны донорын үйлсийг сурталчлах, эгнээг өргөжүүлэхтэй холбоотой сургалт, сурталчилгааны ажлыг хэрэгжүүлэх;

21.2.2.цусны донорт эрүүл мэндийн үзлэг хийх, цус, түүний бүрэлдэхүүн хэсгээ өгснөөр эрүүл мэндэд нь учирч болох үр дагаварын талаар бүрэн мэдээлэл өгөх;

21.2.3.донорын цусанд хийгдсэн шинжилгээний хариуг цусны донорт өөрт нь танилцуулах, зөвлөгөө өгөх;

21.2.4.цусны донорын үүрэг гүйцэтгэж байгаа донорт урвал, хүндрэл үүссэн тохиолдолд тогтоосон стандарт, журмын дагуу анхан шатны эмнэлгийн тусламж үзүүлэх, яаралтай болон нарийн мэргэжлийн тусламж үзүүлэх шаардлагатай бол бусад эрүүл мэндийн байгууллагад шилжүүлэх;

21.1.5.хууль тогтоомжид заасан бусад үүрэг.

## **ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ ЦУСНЫ ДОНОРЫН ЭГНЭЭГ ӨРГӨЖҮҮЛЭХ**

### **22 дугаар зүйл.Цусны донорын үйлсийг сурталчлах, элсүүлэх**

22.1.Цус сэлбэлт судлалын асуудал хариуцсан эрүүл мэндийн байгууллага нь цусны донорын эгнээг өргөжүүлэх зорилгоор донорын хөдөлгөөнийг сурталчлах, элсүүлэх ажлыг хэрэгжүүлэх, мэргэжил, арга зүйгээр хангах, Монголын улаан загалмай нийгэмлэг, төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжтэй хамтран зохион байгуулна.

22.2.Төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалтан, иргэн нь цусны донорын үйлсийг сурталчлах, эгнээг өргөжүүлэх, тэдгээрт зориулсан сургалт явуулахад цус сэлбэлт судлалын асуудал хариуцсан эрүүл мэндийн байгууллагад дэмжлэг үзүүлнэ.

22.3.Цусны донорын нийгмийн ач холбогдол, цусны донорын талаарх ойлголтыг ерөнхий боловсролын ахлах ангийн болон их, дээд сургуулийн эрүүл мэндийн сургалтын хөтөлбөрт тусгана.

22.4.Орон нутгийн гамшгаас хамгаалах нөөц сангийн тодорхой хэсгийг цусны донорын сургалт сурталчилгаа, цус, цусан бүтээгдэхүүний нөөц бүрдүүлэхэд зарцуулж, гамшиг, нийгмийн эрүүл мэндийн онцгой байдлын сургалт, дадлагын төлөвлөгөөнд цусны донороос цус, түүний бүрэлдэхүүн хэсэг цуглуулах, цус, цусан бүтээгдэхүүний нөөц бүрдүүлэхтэй холбоотой үйл ажиллагааг тусгана.

### **23 дугаар зүйл.Цусны донорын үйлсэд идэвхтэй оролцсон иргэн, байгууллагыг алдаршуулах, урамшуулах**

23.1. Бүхэл цусаа 35, цус, түүний бүрэлдэхүүн хэсгээ 50 түүнээс дээш удаа болон ховор бүлгийн цус, түүний бүрэлдэхүүн хэсгээ 25 түүнээс дээш удаа өгсөн

донорыг Монгол Улсын Засгийн газрын шагнал Цусны хүндэт донор тэмдгээр шагнаж, алдаршуулна.

23.2.Цусны хүндэт донор болох эрх үүссэнийг тодорхойлох, шагнах журмыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тогтооно.

23.3.Цусны донорыг алдаршуулах, урамшуулах зорилгоор эд материал, санхүүгийн дэмжлэг, тусламж үзүүлж болох бөгөөд төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, байгууллагаас шагнаж урамшуулж болно.

23.4.Цус сэлбэлт судлалын асуудал хариуцсан тусгай мэргэжлийн төв нь цусны донорын алдаршуулалт, нийгмийн халамж, дэмжлэг хүртэх шалгуур, болзол хангасан цусны донорын бүртгэл мэдээллийн санг ажиллуулах бөгөөд холбогдох байгууллагад мэдээллийг тогтмол хүргүүлнэ.

#### **24 дүгээр зүйл.Цусны донорт үзүүлэх дэмжлэг**

24.1.Цус, түүний бүрэлдэхүүн хэсгээ өгсөн донорт цус, түүний бүрэлдэхүүн хэсэг цуглуулсан эмнэлгийн байгууллагын зардлаар илчлэг нөхөх хүнсний бүтээгдэхүүнээр үйлчилнэ.

24.2.Монгол Улсын Засгийн газрын шагнал Цусны хүндэт донор тэмдгээр шагнагдсан цусны донорт дараах дэмжлэг үзүүлнэ:

24.2.1.нийслэл, аймгийн төвийн нийтийн тээврийн хэрэгсэл /таксинаас бусад/-ээр үнэ төлбөргүй зорчих;

24.2.2.эмнэлгийн тусламж, үйлчилгээг хөнгөлөлттэй үзүүлэх, жилд нэг удаа эрүүл мэндийн үзлэгт үнэ төлбөргүй хамрагдах;

24.2.3.магадлан итгэмжлэгдсэн дотоодын рашаан сувилалд жилд нэг удаа үнэ төлбөргүй сувилуулах.

24.3.Энэ хуулийн 24.2-т заасан дэмжлэгийг Ахмад настны тухай хууль, бусад хууль тогтоомжоор тогтоосон дэмжлэгтэй давхардуулан олгохгүй.

24.4.Цусны байнгын донорт эмнэлгийн тусламж, үйлчилгээг хөнгөлөлттэй үзүүлэх, жилд нэг удаа эрүүл мэндийн үзлэгт үнэ төлбөргүй хамруулах журмыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, магадлан итгэмжлэгдсэн дотоодын рашаан сувилалд жилд нэг удаа үнэ төлбөргүй сувилуулах журмыг хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тус тус батална.

24.5.БНМАУ-ын Хүндэт донор, МУЗН-ийн Хүндэт донор энгэрийн тэмдэгтэй иргэд дээрх дэмжлэгийг мөн адил хүртэнэ.

### **ТАВДУГААР БҮЛЭГ**

#### **ДОНОРООС ЦУС, ТҮҮНИЙ БҮРЭЛДЭХҮҮН ХЭСЭГ АВАХ, ШИНЖЛЭХ, БОЛОВСРУУЛАХ, ХАДГАЛАХ, ТЭЭВЭРЛЭХ, СЭЛБЭХ**

## **25 дугаар зүйл.Цус, түүний бүрэлдэхүүн хэсгийг цуглуулах, боловсруулах, хадгалах, тээвэрлэх**

25.1.Цус, түүний бүрэлдэхүүн хэсгийг дараах байгууллага цуглуулж, боловсруулан, хадгалж, тээвэрлэнэ:

25.1.1.цус сэлбэлт судлалын асуудал хариуцсан тусгай мэргэжлийн төв;

25.1.2.цусны төв.

25.2.Энэ зүйлийн 25.1 дэх хэсэгт заасан эрүүл мэндийн байгууллага холбогдох журмын дагуу авсан тусгай зөвшөөрөл, магадлан итгэмжлэлтэй байна.

25.3.Энэ зүйлийн 25.1.1-д заасан тусгай мэргэжлийн төв цус, түүний бүрэлдэхүүн хэсгийг явуулын багаар цуглуулах хөдөлгөөнт иж бүрдэлтэй байна.

25.4.Цус, цусан бүтээгдэхүүний тээвэрлэлтийг цусны донорын үйл ажиллагаанд оролцогч эрүүл мэндийн байгууллага гүйцэтгэж болно.

25.5.Алслагдсан сумын эрүүл мэндийн төвд хойшлуулшгүй тохиолдолд, зохих шаардлагыг хангасан нөхцөлд цус цуглуулж, шинжилж, сэлбэж болно.

## **26 дугаар зүйл.Цус, цусан бүтээгдэхүүнийг хэрэглэх**

26.1.Цусны донорын үйл ажиллагаанд оролцогч дараах байгууллага эмчилгээний зорилгоор цус, цусан бүтээгдэхүүнийг хэрэглэнэ:

26.1.1.өмчийн болон эрх зүй, зохион байгуулалтын хэлбэрээс үл хамааран эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэгч эрүүл мэндийн байгууллага;

26.1.2.анагаах ухааны боловсрол олгох боловсролын байгууллагын эмнэлэг.

26.2.Энэ зүйлийн 26.1 дэх хэсэгт заасан байгууллага нь цус, цусан бүтээгдэхүүн сэлбэлтийн дараа үүссэн урвал хүндрэлийг тогтоосон журмын дагуу цус сэлбэлт судлалын асуудал хариуцсан тусгай мэргэжлийн төвд мэдээлэх үүрэгтэй.

26.3.Цус, цусан бүтээгдэхүүнийг эмчилгээний бус зорилгоор хэрэглэхийг хориглоно.

## **27 дугаар зүйл.Донорын цус, цусан бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх**

27.1.Монгол Улсын олон улсын гэрээ, хэлэлцээрийн дагуу чанар, аюулгүй байдлын хувьд баталгаажсан цус, цусан бүтээгдэхүүнийг экспортолж, импортлож болно.

27.2.Цус, цусан бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх журмыг Засгийн газар батална.

**ЗУРГААДУГААР БҮЛЭГ  
ГАМШИГ, НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН  
ҮЕИЙН ХАРИЛЦАА**

**28 дугаар зүйл.Гамшиг, нийгмийн эрүүл мэндийн онцгой байдлын үед цус, цусан бүтээгдэхүүний нөөц, хангамжийн зохицуулалт**

28.1.Гамшиг, аюулт үзэгдэл, осол, цар тахал болон бусад онцгой байдлын үед цус, түүний бүрэлдэхүүн хэсэг цуглуулах зохион байгуулалтыг улсын хэмжээнд Гамшгаас хамгаалах эрүүл мэндийн улсын алба, тодорхой нутаг дэвсгэрт гамшгаас хамгаалах бэлэн байдлын зэрэгт шилжсэн үед цус, түүний бүрэлдэхүүн хэсэг цуглуулах зохион байгуулалтыг орон нутгийн Онцгой комиссын удирдлага дор явуулна.

28.2.Гамшиг, нийгмийн эрүүл мэндийн онцгой байдлын үед цус, түүний бүрэлдэхүүн хэсгээ өгөх боломжтой хүн амын дунд сурталчилгаа явуулах, тэднээс цус цуглуулах үйл ажиллагаатай холбоотой зохион байгуулалтыг онцгой байдлын асуудал эрхэлсэн болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүдийн хамтран баталсан журмын дагуу хэрэгжүүлнэ.

28.3.Энэ хуулийн 14.3-т заасан хөтөлбөрт бүрэн хамрагдсан оюутан, цус сэлбэлт судлалын чиглэлээр төрөлжсөн мэргэшил эзэмшсэн эмнэлгийн мэргэжилтнийг энэ хуулийн 28.1-д заасан тохиолдолд цус, түүний бүрэлдэхүүн хэсэг цуглуулах үйл ажиллагаанд дайчилгаагаар ажиллуулж болно.

28.4.Энэ хуулийн 28.1-д заасан тохиолдолд үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагын бие бүрэлдэхүүн, болон бусад төрийн албан хаагчдаас цус, цусан бүтээгдэхүүний нөөцийг бүрдүүлж болно.

28.5.Энэ хуулийн 28.2-т заасан үйл ажиллагаанд хамрагдсан цусны донорт өгөх илчлэг нөхөх хүнсний бүтээгдэхүүнийг тухайн цусны донорын харьяалагдах байгууллага олгоно.

28.6.Энэ хуулийн 28.1, 28.3, 28.5-д заасантай холбоотой зардлыг Засгийн газрын нөөц сангаас санхүүжүүлнэ.

**ДОЛООДУГААР БҮЛЭГ  
ЦУСНЫ ДОНОРЫН МЭДЭЭЛЛИЙН САН**

**29 дүгээр зүйл.Цусны донорын мэдээллийн сан**

29.1.Цус, цусан бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах, түүнд хяналт тавих зорилгоор цусны донорын мэдээллийн санг үүсгэж, баяжуулна.

29.2.Цусны донорын мэдээллийн сан нь дараах зорилтыг хангана:

29.2.1.цусны донор болон сэлбүүлэгчийн хувийн байдлыг тогтоох;

29.2.2.цус, түүний бүрэлдэхүүн хэсгийн цуглуулалт, шинжилгээ, боловсруулалт, хадгалалт, тээвэрлэлттэй холбоотой үйл ажиллагааг тандан тодруулах;

29.2.3.цус, түүний бүрэлдэхүүн хэсгийг шинжлэх, боловсруулах, хадгалах, тээвэрлэх, эмчилгээнд хэрэглэх, устгахтай холбоотой үйл ажиллагааг танин тодруулах, мөшгөн тогтоох боломж бүрдүүлэх;

29.2.4.цус сэлбэлтийн дараах урвал, хүндрэлийг бүртгэх, шалтгааныг судлан тогтоох.

29.3.Цусны донорын мэдээллийн санд бодит хугацаагаар дараах мэдээллийг тусгана:

29.3.1.өгсөн цус, түүний бүрэлдэхүүн хэсгийн хэмжээ;

29.3.2.цусны бүлэг, резусын дэд бүлгийн мэдээллийг тусгасан нөөцийн хэмжээ;

29.3.3.цус сэлбэлтийн дараа сэлбүүлэгчид илэрсэн урвал, хүндрэлийн мэдээлэл;

29.3.4.цус, цусан бүтээгдэхүүний нөөцийн хөдөлгөөний мэдээлэл;

29.3.5.цусны донорын үйл ажиллагаанд оролцогч байгууллагын цус сэлбэлт судлалын чиглэлээр хэрэгжүүлж байгаа үйл ажиллагааны мэдээлэл;

29.3.6.импортлож, экспортлосон цус, цусан бүтээгдэхүүний тоо, хэмжээ, давтамж;

29.3.7.цус, түүний бүрэлдэхүүн хэсэг авахыг хориглосон болон түр хугацаанд түдгэлзүүлсэн цусны донорын мэдээлэл.

29.4.Цус, цусан бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах зорилгоор донор бүрт бүртгэлийн дугаар олгоно.

29.5.Бүртгэлийн дугаарт дараах мэдээлэл агуулагдсан байна:

29.5.1.овог, нэр, хэрэв овог нэрээ өөрчилсөн бол өөрчлөгдсөн тухай мэдээлэл;

29.5.2.төрсөн огноо;

29.5.3.хүйс;

29.5.4.түр болон байнга оршин сууж байгаа бүртгэлтэй хаяг;

29.5.5.иргэний үнэмлэх болон хувийн байдлыг тогтоосон баримт бичгийн хуулбар;

29.5.6.бүртгэлийн дугаар олгогдсон огноо;

29.5.7.цусны бүлэг, резусын дэд бүлгийн мэдээлэл;

29.5.8.өмнө цус, түүний бүрэлдэхүүн хэсэг өгсөн мэдээлэл;

29.5.9.цус, түүний бүрэлдэхүүн хэсэг өгөхийг хориглосон болон түр хугацаанд түдгэлзүүлсэн мэдээлэл;

29.5.10.Цусны хүндэт донор тэмдгээр шагнагдсан тухай мэдээлэл.



29.6.Цусны донорын мэдээллийн сан нь төрийн онц чухал мэдээллийн дэд бүтцэд хамаарах бөгөөд төрийн мэдээллийн нэгдсэн сүлжээгээр цусны төв, цус, цусан бүтээгдэхүүн хэрэглэгч эрүүл мэндийн байгууллагуудтай холбогдсон байна.

### **30 дугаар зүйл.Цусны донорын мэдээллийн санг ажиллуулах байгууллага**

30.1.Цусны донорын мэдээллийн нэгдсэн санг цус сэлбэлт судлалын асуудал хариуцсан тусгай мэргэжлийн төв бүрдүүлэн хөтөлнө.

30.2.Цусны төв цусны донорын мэдээллийн санд тогтмол баяжуулалт хийнэ.

30.3.Цусны донорын мэдээллийн санд тусгах бүртгэлийн дугаар, хугацаа, оруулах мэдээллийн хэлбэр, мэдээллийн санд нэвтрэх журмыг Кибер халдлага, зөрчилтэй тэмцэх үндэсний төвтэй зөвшилцөн, эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

30.4.Цусны донорын мэдээллийн санд зайлшгүй тусгах шаардлагатай мэдээллийг цусны донор, сэлбүүлэгч, түүний хууль ёсны төлөөлөгч болон цусны донорын үйл ажиллагаанд оролцогч байгууллагууд хариу төлбөргүйгээр цус сэлбэлт судлалын асуудал эрхэлсэн тусгай мэргэжлийн төвд өгөх үүрэгтэй.

## **НАЙМДУГААР БҮЛЭГ ХАРИУЦЛАГА**

### **31 дүгээр зүйл.Хуулийн хэрэгжилтэд хяналт тавих**

31.1.Цусны донорын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, мэргэжлийн хяналтын болон холбогдох бусад байгууллага хяналт тавина.

### **32 дугаар зүйл.Цусны донорын үйл ажиллагааны журмыг зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага**

32.1.Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

32.2.Энэ хуулийг зөрчсөнөөс хүний амь нас, эрүүл мэнд хохирсон, амь нас хохирох нөхцөл бүрдсэн, эрүүл мэндээр хохирсон бол хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

---oOo---